



Аудитын код: САГ-2018/161/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn


Стандарт дүгнэлт аудит ХХК
Цахим хаяг: SD_audit@yahoo.com

Аудитор В.Даваасүрэн
Утас: 88099001

Аудитор Х.Эрдэнэцэцэг
Утас: 99136376

Аудитор У.Тунгалаг
Утас: 99167939


Аудитор Ч.Поотой
Утас: 99192225



Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
2.5	Дотоод хяналт	4
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	5
2.7	Шилэн дансны мэдээлэл	6
2.8	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	6
2.9.1	Мөнгөн хөрөнгө	6
2.9.2	Бараа материал.....	6
2.9.3	Үндсэн хөрөнгө.....	7
2.10	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал	9
3.1	Мөнгөн хөрөнгө	10
3.2	Бараа материал.....	11
3.3	Үндсэн хөрөнгө	12
4	Аудит хийсэн Санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	0
4.5	Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан	1
4.6	Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан	4



1 Аудитын гэрчилгээ

ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН ТӨВ МУЗЕЙН ЗАХИРАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдээгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Үлэг гүрвэлийн төв музейн захирал Н. Жавзмаа таньд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дугаар сарын 22-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 24-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Стандарт дүгнэлт аудит” ХХК хариуцаж Аудитор В.Даваасүрэн, Х.Эрдэнэцэцэг, У.Тунгалаг, Ч.Поотой нар хэрэгжүүлэв.

Үлэг гүрвэлийн төв музей 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018 оны 01 дүгээр сарын 25-нд “Стандарт дүгнэлт аудит” ХХК-д 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 23-01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Үлэг гүрвэлийн төв музей “Түүх соёлын өвийг хадгалж хамгаалах, бүртгэн баримтжуулах, хойч үедээ өвлөн уламжлуулах, палеонтологийн олдворуудаар музейн сан хөмрөг баяжуулах, баримтжуулан хадгалах, нэгдсэн мэдээллийн сантай болох, соёлын өвийг нийтэд нээлттэй дэлгэн үзүүлэх” эрхэм зорилгын дор музейн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үлэг гүрвэлийн төв музей хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд: Палеонтологийн олдвор, соёлын өвийг

- Хадгалж хамгаалах
- Бүртгэн баталгаажуулах
- Өвлөн уламжлуулах
- Эрж хайж цуглуулах, зурагжуулан хадгалах
- Гадаад орнуудад байгаа олдворуудаа олж тогтоох
- Үзмэр үзүүлэн болгон дэлгэн үзүүлэх, сурталчлах

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн Аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримжууллаа./ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 30 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1 хувиар тооцож 5,326.9 мянган төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “ACOLOUS” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.



2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг

шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцүүлсэн байна.

Үлэг гүрвэлийн төв музей төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг ТАБ-СТА-В-2 маягтын дагуу үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Үлэг гүрвэлийн төв музейн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн“ACOLOUS” програм хангамж ашиглажээ.

2.6 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Үлэг гүрвэлийн төв музей өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 441,930.2 мянган төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	441,930.2	436,674.4	98.8%	
1.1	Урсгал зардал	441,930.2	436,674.4	98.8%	
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	441,930.2	436,674.4	98.8%	
2.1	Улсын төсвөөс санхүүжих	388,530.9	380,491.3	97.9%	
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	53,399.3	56,183.1	105.2%	

Төсөвт зардлын гүйцэтгэл 5,255.7 мянган төгрөг буюу 2.2 хувиар буурсан нь цагийн хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 684.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,784.6 мянга, томилолтын зардлыг 1,083.0 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 1,687.0 төгрөгөөр хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3 хувь буюу 1,784,6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь түлш халаалтын зардал 37.3 хувь буюу 14,266.8 мянган төгрөгөөр хэмнэгдэж,

гэрэл цахилгааны зардал 47.4 хувь буюу 10,091.2 мянган төгрөгөөр хэтэрч, цэвэр бохир усны зардал 401.2 хувь 2,391.0 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэнтэй холбоотой байна.

Дээрх зардлууд хэмнэгдсэн шалтгаан нь төсвийн төлөвлөлтийг бодитой хийгээгүй, урсгал болон хөрөнгийн санхүүжилтийг бүрэн хийгээгүйтэй холбоотой байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Үлэг гүрвэлийн төв музей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.8 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Үлэг гүрвэлийн төв музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг (ТАБ-СТА-А-5-1, ТАБ-СТА-А-5-2) маягтад нэгтгэж, баримтжуулав.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг (ТАБ-СТА-А-5-3) маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт 26 эрсдэлтэй асуудал тодорхойлж, түүнийг сорих 26 горим сорил боловсруулав

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэл хөтлөлтөнд эхний үлдэгдлийг 500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байсан. Энэ нь НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “НББ хөтлөлтөнд гарсан алдааг, алдаа гарсан шалтагаан залруулах аргыг тодорхой тусгасан баримт тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Шалтгааныг судалж, баримтжуулан НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасныг мөрдөн ажиллах. Аудитын явцад залруулга хийсэн болно.



2.9.2 Бараа материал

Бараа материалын бүртгэл хөтлөлтийн орлого, зарлагын баримтуудын огноо зөрүүтэйн улмаас дутуу орлого харагдаж байна. Энэ нь НББТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д “Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Бараа материалын бүртгэлийг НББОУС-2 заасны дагуу буюу НББТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д заасан “Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэх” гэж заасны дагуу хийж гүйцэтгэх.

2.9.3 Үндсэн хөрөнгө

Бусад үндсэн хөрөнгө, “Биет бус хөрөнгө” болох нийт 12,468.5 мянган төгрөгийн хөрөнгө нь анхны өртөгөө элэгдлээрээ нөхсөн байна. Энэ нь НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, баримтжуулах ажлыг зохион байгуулах” гэсэн зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, баримтжуулах ажлыг зохион байгуулах” гэсэн заалтын дагуу бусад үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийг дахин үнэлүүлж ашиглах боломжтой эсэхийг судалж шийдвэрлэх.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 26 эрсдэлтэй асуудалд 26 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. (ТАБ-СТА-В-3.1 - ТАБ-СТА-В-3.7)

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 50 хувь буюу 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Аудитын явцад залруулга гараагүй.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Мянган төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	978.3	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн			
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн			
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн			
	Дүн	2	978.3	



Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал гараагүй

2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов. (ТАБ-СТА-А-4)

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн байгууллагын хувьд материаллаг байдлын суурийг төсвийн зардлаар тооцох нь оновчтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 532,692.4 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 5,326.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь өмнөх аудитуудаар зөрчилгүй санал дүгнэлт авч байсан, эрсдэл бага гэж үнэлсэнтэй холбоотой.


2.14 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг менежментийн захидалд тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүдэв.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үлэг гүрвэлийн төв музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.



3.1 Мөнгөн хөрөнгө	
<p><u>Илрүүлэлт</u></p> <p>Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэл хөтлөлтөнд эхний үлдэгдлийг 500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байсан. Энэ нь НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “НББ хөтлөлтөнд гарсан алдааг, алдаа гарсан шалтагаан залруулах аргыг тодорхой тусгасан баримт тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.</p>	<p><u>Зөвлөмж</u></p> <p>Шалтгааныг судалж, баримтжуулан алдаатай бичсэн зүйлийг цаг тухайд нь залруулж байх.</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 04 сарын 05-ны дотор Стандарт дүгнэлт аудит ХХК-д ирүүлэх.</p>
<p><u>Эрсдэл</u></p> <p>Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, Өмч хөрөнгө зүй бусаар зарцуулагдах</p>	<p><u>Төсвийн захирагчийн хариу</u></p> <p>Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ.</p>



3.2 БАРАА МАТЕРИАЛ	
<p><u>Илрүүлэлт</u></p> <p>Бараа материалын бүртгэл хөтлөлтийн орлого, зарлагын баримтуудын огноо зөрүүтэйн улмаас дутуу орлого харагдаж байна. Энэ нь НББТХ-н 14 дүгээр зүйлийн 14.4.5-д заасан “Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэх” зүйлийг зөрсөн байна.</p>	<p><u>Зөвлөмж</u></p> <p>Бараа материалын бүртгэлийг цаашид чанд мөрдөн ажиллах.</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 04 сарын 05-ны дотор Стандарт дүгнэлт аудит ХХК-д ирүүлэх.</p>
<p><u>Эрсдэл</u></p> <p>Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, Өмч хөрөнгө зүй бусаар зарцуулагдах</p>	<p><u>Төсвийн захирагчийн хариу</u></p> <p>Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ.</p>



3.3 Үндсэн хөрөнгө	
<p><u>Илрүүлэлт</u></p> <p>Бусад үндсэн хөрөнгө, "Биет бус хөрөнгө" болох нийт 12,468.5 мянган төгрөгийн хөрөнгө нь анхны өртөгөө элэгдлээрээ нөхсөн байна. Энэ нь НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, баримтжуулах ажлыг зохион байгуулах" гэж заасныг зөрчсөн байна.</p>	<p><u>Зөвлөмж</u></p> <p>Бусад үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийг дахин үнэлүүлж ашиглах боломжтой эсэхийг судлаж шийдвэрлэх.</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 04 сарын 05-ны дотор Стандарт дүгнэлт аудит ХХК-д ирүүлэх.</p>
<p><u>Эрсдэл</u></p> <p>Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,</p> <p>Өмч хөрөнгө зүй бусаар зарцуулагдах</p>	<p><u>Төсвийн захирагчийн хариу</u></p> <p>Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ.</p> <div style="border: 1px solid green; padding: 5px; margin-top: 10px; display: flex; align-items: center;"> <div style="border: 1px solid green; padding: 5px; margin-right: 10px; font-size: 24px; font-weight: bold;">01</div> <div style="text-align: center;"> <p style="font-size: 10px; margin: 0;">ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА</p> <p style="font-size: 14px; font-weight: bold; margin: 0;">ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ</p> </div> </div>

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>82,621,785.50</u>	<u>100,584,632.50</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	82,621,785.50	100,584,632.50
351	Түүхий эд материал	40,567,336.50	49,508,999.00
35110	Тусгай зориулалттай материал	40,567,336.50	49,508,999.00
354	Хангамжийн материал	42,054,449.50	51,075,633.50
35410	Бичиг хэргийн материал	5,781,043.00	7,579,403.00
35420	Аж ахуйн материал	2,776,685.00	9,187,809.00
35440	Түлш, шатах тослох материал		460,000.00
35450	Барилгын засварын материал		52,500.00
35470	Бусад хангамжийн материал	33,496,721.50	33,795,921.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,825,991,030.70</u>	<u>1,758,885,276.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>1,825,991,030.70</u>	<u>1,758,885,276.54</u>
392	Биет хөрөнгө	<u>1,825,991,030.70</u>	<u>1,758,885,276.54</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,801,356,300.00	1,801,356,300.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(90,067,815.12)	(135,101,722.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,022,240.54	89,832,029.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,880,125.34)	(71,370,927.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,378,344.54	57,214,344.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,672,361.70)	(25,044,747.82)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	42,000,000.00	42,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,778,500.00	3,778,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,912,593.75)	(3,778,500.00)
393	Биет бус хөрөнгө	<u>1,988,541.54</u>	
39301	Програм хангамж	990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(772,291.69)	(990,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,700,000.00	7,700,000.00
39304	Хасагдуулга	(5,929,166.77)	(7,700,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,908,612,816.21</u>	<u>1,859,469,909.04</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,908,612,816.21</u>	<u>1,859,469,909.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,908,612,816.21	1,859,469,909.04
512	Хуримтлагдсан үр дүн	1,908,612,816.21	1,859,469,909.04
51210	Өмнөх үеийн үр дүн	1,970,567,254.11	1,908,612,816.21
51220	Тайлант үеийн үр дүн	-61,954,437.90	(49,142,907.17)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,908,612,816.21</u>	<u>1,859,469,909.04</u>



4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	231,373,000.00	483,549,499.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,031,300.00	95,018,599.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,031,300.00	95,018,599.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,031,300.00	95,018,599.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,306,500.00	90,128,710.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	724,800.00	4,889,889.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	223,341,700.00	388,530,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	223,341,700.00	388,530,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	223,341,700.00	388,530,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	242,141,304.02	532,692,406.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,141,304.02	516,252,836.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,141,304.02	516,252,836.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,315,494.01	268,540,781.58
210101	Үндсэн цалин	100,812,161.68	228,997,183.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,503,332.33	22,665,000.00
210104	Урамшуулал		16,878,598.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,220,000.29	29,445,728.26
210201	Тэтгэврийн даатгал	11,042,903.21	19,365,528.05
210202	Тэтгэмжийн даатгал	816,849.33	2,520,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,020,772.70	2,016,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	213,010.12	504,000.21
210205	Эрүүл мэндийн даатгал	2,126,464.93	5,040,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,408,857.00	58,328,925.76
210301	Гэрэл, цахилгаан	11,186,000.00	31,375,021.00
210302	Түлш, халаалт	18,910,159.24	23,966,918.00
210303	Цэвэр, бохир ус	312,697.76	2,986,986.76
2104	Хангамж, бараа материалын зардал	10,551,921.52	18,737,403.42
210401	Бичиг хэрэг	3,621,844.00	4,803,967.00
210402	Тээвэр, шатахуун	210,000.00	1,405,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,795,901.52	3,388,727.42
210404	Ном, хэвлэл	212,312.00	2,046,588.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,711,867.00	7,092,621.00
2105	Нормативт зардал	1,435,520.00	1,293,444.00
21051	Эм	9,000.000	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,426,520.00	1,293,444.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	992,800.00	6,639,060.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,500.00	-
210604	Урсгал засвар	971,300.00	6,639,060.00
2107	Томилот, зочны зардал	1,433,425.00	380,000.00



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
210702	Дотоод албан томилолт	1,433,425.00	380,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,006,000.00	54,429,694.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,600,000.00	45,125,008.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		890,000.00
210807	Газрын төлбөр		414,656.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,406,000.00	8,000,030.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,777,283.20	78,457,799.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,229,434.00	6,706,256.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,538,849.20	71,751,543.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		16,439,569.98
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		8,039,569.98
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	8,039,569.98
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,400,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(10,768,304.02)	(49,142,907.17)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(10,768,304.02)	(49,142,907.17)




4.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>205,205,900.00</u>	<u>484,047,506.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,306,500.00	91,819,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,306,500.00	91,819,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,306,500.00	91,819,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,306,500.00	90,128,710.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,691,240.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	197,899,400.00	392,227,556.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	197,899,400.00	388,530,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	197,899,400.00	388,530,900.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		3,696,656.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		3,696,656.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>199,430,334.04</u>	<u>482,791,606.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>199,430,334.04</u>	<u>482,791,606.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>199,430,334.04</u>	<u>466,352,036.02</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126,151,701.68	271,898,877.56
210101	Үндсэн цалин	111,346,522.68	232,355,279.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,805,179.00	22,665,000.00
210104	Үр дүнгийн урамшуулал		16,878,598.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,460,848.84	29,784,288.28
210201	Тэтгэврийн даатгал	10,143,704.64	19,704,088.28
210202	Тэтгэмжийн даатгал	663,428.48	2,520,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	829,286.31	2,016,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	165,857.12	504,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,658,572.29	5,040,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,408,857.00	58,328,925.76
210301	Гэрэл, цахилгаан	11,186,000.00	31,375,021.00
210302	Түлш, халаалт	18,910,159.00	23,966,918.00
210303	Цэвэр, бохир ус	312,697.76	2,986,986.76
2104	Хангамж, бараа материалын зардал	6,822,901.52	18,775,547.42
210401	Бичиг хэрэг	2,820,600.00	6,633,170.00
210402	Тээвэр, шатахуун	210,000.00	1,860,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,795,901.52	3,388,727.42
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,996,400.00	6,893,150.00
2105	Нормативт зардал	1,412,500.00	3,214,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,412,500.00	3,214,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,542,500.00	2,300,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,116,000.00	170,500.00
210604	Урсгал засвар	1,426,500.00	2,130,100.00

2107	Томилолт, зочны зардал	1,433,425.00	380,000.00
210702	Дотоод албан томилолт	1,433,425.00	380,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,556,500.00	74,744,517.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,197,500.00	69,975,111.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	890,000.00
210807	Газрын төлбөр		414,656.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,459,000.00	3,464,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,641,100.00	6,924,780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,691,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,641,100.00	5,233,540.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		16,439,569.98
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		8,039,569.98
213102	Засгийн газрын тодоод шилжүүлэг		8,039,569.9
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,400,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,775,565.96	1,255,900.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	2,011,577.00	
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа эргэн төлбөр	2,011,577.00	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		1,255,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,255,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр		1,255,900.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1,255,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	2,011,577.00	1,255,900.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,787,142.96	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00




4.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1.	2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	0.00	0.00	1,970,567,254.11	1,970,567,254.11
2.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3.	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,970,567,254.11	1,970,567,254.11
4.	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
5.	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
6.	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
7.	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	-10,768,304.02	-10,768,304.02
8.	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
9.	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	1,908,612,816.21	1,908,612,816.21
10.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
11.	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,908,612,816.21	1,908,612,816.21
12.	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
13.	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
14.	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	-49,142,907.17	-49,142,907.17
15.	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	1,859,469,909.04	1,859,469,909.04




4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,930,200.00	436,674,450.02	5,255,749.98	98.8%
УРСГАЛ ЗАРДАЛ	441,930,200.00	436,674,450.02	5,255,749.98	98.8%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,530,200.00	436,674,450.02	5,255,749.98	98.8%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,007,800.00	251,323,623.56	684,176.44	99.7%
Үндсэн цалин	229,342,800.00	228,658,623.56	684,176.44	99.7%
Унаа хоолны хөнгөлөлт	22,665,000.00	22,665,000.00		100.0%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,644,700.00	28,644,699.28	0.72	100.0%
Тэтгэврийн даатгал	18,564,500.00	18,564,499.28	0.72	100.0%
Тэтгэмжийн даатгал	2,520,000.00	2,520,000.00		100.0%
ҮОМШӨ-ний даатгал	2,016,000.00	2,016,000.00		100.0%
Ажилгүйдлийн даатгал	504,000.00	504,000.00		100.0%
Эрүүл мэндийн даатгал	5,040,200.00	5,040,200.00		100.0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,113,500.00	58,328,925.76	1,784,574.24	97.0%
Гэрэл, цахилгаан	21,283,800.00	31,375,021.00	(10,091,221.00)	147.4%
Түлш, халаалт	38,233,700.00	23,966,918.00	14,266,782.00	62.7%
Цэвэр, бохир ус	596,000.00	2,986,986.76	2,390,986.76	501.2%
Хангамж, бараа материалын зардал	18,777,500.00	18,775,547.42	1,952.58	100.0%
Бичиг хэрэг	6,561,300.00	6,633,170.00	71,870.00	101.1%



Үлэг гүрвэлийн төв музейн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Тээвэр, шатахуун	2,276,300.00	1,860,500.00	415,800.00	81.7%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,032,300.00	3,388,727.42	356,427.42	111.8%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,907,600.00	6,893,150.00	14,450.00	99.8%
Нормативт зардал	3,214,500.00	3,214,500.00		100.0%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,214,500.00	3,214,500.00		100.0%
Эд хогшил, урсгал засварын зардал	3,245,200.00	3,230,500.00	14,700.00	99.5%
Багаж, техник, хэрэгсэл	1,104,800.00	1,100,400.00	4,400.00	99.6%
Урсгал засвар	2,140,400.00	2,130,100.00	10,300.00	99.5%
Томилолт, зочны зардал	1,463,000.00	380,000.00	1,083,000.00	26.0%
Дотоод албан томилолт	1,463,000.00	380,000.00	1,083,000.00	26.0%
Зочин төлөөлөгч хүлээн авах				
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,830,100.00	59,143,114.00	1,686,986.00	97.2%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,489,300.00	54,373,708.00	1,115,592.00	98.0%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	891,000.00	890,000.00	1,000.00	99.9%
Тээврийн хэрэгслийн татвар	178,200.00		178,200.00	
Газрын төлбөр	806,600.00	414,656.00	391,944.00	54.1%
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,465,000.00	3,464,750.00	250.00	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	5,233,900.00	5,233,540.00	360.00	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал				
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,233,900.00	5,233,540.00	360.00	100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,400,000.00	8,400,000.00		100.0%
Бусад урсгал шилжүүлэг	8,400,000.00	8,400,000.00		100.0%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400,000.00	8,400,000.00		100.0%

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,930,200.00	436,674,450.02	5,255,749.98	98.8%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	388,530,900.00	380,491,330.02	8,039,569.98	97.9%
Улсын төсвөөс санхүүжих	388,530,900.00	380,491,330.02	8,039,569.98	97.9%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	53,399,300.00	56,183,120.00	2,783,820.00	105.2%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,399,300.00	56,183,120.00	2,783,820.00	105.2%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	28		100.0%
Удирдах ажилтан	2	2		100.0%
Гүйцэтгэх ажилтан	16	16		100.0%
Үйлчлэх ажилтан	10	10		100.0%

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.6 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		33,945,590.00	33,945,590.00	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		33,945,590.00	33,945,590.00	
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		33,945,590.00	33,945,590.00	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		16,878,598.00	16,878,598.00	
Урамшуулалр		16,878,598.00	16,878,598.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,139,589.00	1,139,589.00	
Тэтгэврийн даатгал		1,139,589.00	1,139,589.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		15,927,403.00	15,927,403.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		15,927,403.00	15,927,403.00	
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		33,945,590.00	33,945,590.00	
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		33,945,590.00	33,945,590.00	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		33,945,590.00	33,945,590.00	
АЖИЛЛАГСДЫН ТОО	28			
Удирдах ажилтан	2			
Гүйцэтгэх ажилтан	16			
Үйлчлэх ажилтан	10			

